# АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН БҮС ОРОН НУТГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН 2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

2025 оны 06 дугээр сарын 10 — Номгон

| № | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хэрэгжилт |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| **Зорилт 1. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх** | | | | | | | |
| 1.1 | Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 2026 оны төсөл, арга хэмжээг төлөвлөх, аймгийн ИТХ-аар батлуулах | - | 2026 оны аймгийн төсөвт Орон нутгийн хөгжлийн сан хавсралтаар батлагдсан байна. | 2025 оны аймгийн төсөвт Орон нутгийн хөгжлийн сан батлагдсан. | Байгуулсан ажлын хэсэг нэгтгэсэн саналыг зөвлөлөөр танилцуулан АИТХурлаар батлуулсан байна. | IV улирал | Хугацаа болоогүй. |
| 1.2 | Монгол Улсын 2026 оны төсвийн төсөлд тусгах саналыг авч нэгтгэн, төсөл арга хэмжээг төлөвлөж, эрэмбэлэн, үнэлж, Улсын төсвийн цахим системд оруулан, холбогдох яамдад хүргүүлэх, батлуулах | - | Аймаг орон нутагт хэрэгтэй бүтээн байгуулалтын томоохон ажлууд 2026 оны Улсын төсөвт батлагдсан байна. | Аймаг орон нутагт хэрэгтэй бүтээн байгуулалтын томоохон ажлууд 2026 оны Улсын төсөвт батлагдсан байна. | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих ажлуудын саналыг сум, байгууллагуудаас авч нэгтгэн, яамдууд руу хүргүүлж, Улсын төсөвт батлагдсан байна. | III,IV улирал | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2026 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний саналын төслийг ttps://pimis.publicinvestment.gov.mn цахим мэдээллийн системээр 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 2025 оны 06 дугаар сарын 01 хүртэл авч нийт 63 төсөл, арга хэмжээний санал хүлээн авч хяналтад авч нэгтгэсэн. Нэгтгэсэн саналыг журмын дагуу холбогдох яамдад 3 дугаар улиралд хүргүүлнэ. Тодорхой үр дүнд хүрсэн 90% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.3 | Төсвийн мэдээллийн ил тод байдлыг хангах зорилгоор холбогдох мэдээллийг Шилэн дансны систем болох www.shilendans.gov.mn сайтад байршуулах | - | Цахимд оруулсан мэдээллийн тоо | 12 | 12 | I-IV улирал | Төсвийн мэдээллийн нээлттэй ил тод байдлыг хангах зорилгоор хагас жилийн байдлаар улсын төсвийн 10 төсөл арга хэмжээнд 6,278.3 сая төгрөгийн санхүүжилтийн гүйцэтгэлийг, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 45 төсөл арга хэмжээний 2,801.4 сая төгрөгийн гүйцэтгэлийг, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих 57 төсөл арга хэмжээний 1,969.5 сая төгрөгийн санхүүжилтийг 80 гаруй ААН-д олгон, мэдээллийг шилэн дансанд хуулийн хугацаанд нь байршуулан ил тод нээлттэй болгосон.<br>Үр дүнтэй 100% |
| 1.4 | Баянхонгор аймгийн Хөгжлийн 2026 оны төлөвлөгөөний төслийг боловсруулж, аймгийн ИТХ-аар батлуулах | - | Батлуулсан төлөвлөгөөний тоо | 1 | 1 | III,IV улирал | Хугацаа болоогүй. |
| 1.5 | Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн харъяа байгууллагуудын үйл ажиллагаа, менежментийг сайжруулах хөндлөнгийн үнэлгээ хийлгэх | Орон нутгийн төсөв 20,0 сая төгрөг | Хөндлөнгийн үнэлгээний тоо | 0 | 1 | II улирал | Арга хэмжээг хэрэгжүүлэх төсөв хүрэлцэхгүй шалтгааны улмаас тодотголоор төсөв нэмүүлэх саналыг АИТХ-ын хуралдаанд танилцуулахаар бэлтгэж байна.<br>Хэрэгжилт хангалтгүй 30% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.6 | Сумдын барилга, байгууламжид үнэлгээ хийх, хөрөнгө оруулалтын санал авах, эрэмбэлэх | Байгууллагын төсөв | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 0 | 100% | I улирал | Хугацаа болоогүй. |
| 1.7. | Бодлогын баримт бичиг, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хугацаанд нь цахимаар тайлагнах | - | Тайлагналтын тоо | 12 | 12 | I-IV улирал | Эхний хагас жилийн байдлаар Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг 2 удаа, Аймгийг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, аймгийн 2024 оны жилийн хөгжлийн төлөвлөгөө, Засгийн газрын гишүүн – аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээ, аймгийн Засаг даргын захирамж, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолын хэрэгжилтийг тус бүр 1 удаа нийт 7 бодлогын баримт бичгийн хэргэжилтийг цахимаар тайлагнасан.<br>Тодорхой үр дүнд хүрсэн – 90% |
| **Зорилт 2. Хөдөө аж ахуйн салбарын тогтвортой хөгжлийг хангах** | | | | | | | |
| 2.1 | Аймгийн аюулгүйн нөөцийн өвс, тэжээлийг бүрдүүлэх | Нөөцийн хэмжээ тн | 270 | 0 | 100 | III-IV улирал | Хугацаа болоогүй. |
| 2.2 | Бод малын зохиомол хээлтүүлэг хийх ажлыг зохион байгуулах | Хээлтүүлэг хийсэн малын тоо | 150 | 100 | 100 | II улирал | Малын тарга тэвээргээс шалтгаалан зохиомол хээлтүүлэг хийх хугацаа болоогүй байна. Тус ажлын төлөвлөгөөг гаргах, шаардлагатай нэг удаагийн хэрэгсэл, үрийн захиалгыг холбогдох байгууллагуудад хүргүүлэн ажиллаж байна. Санхүүжилт орж ирээгүй байна.<br>Эрчимжүүлэх шаардлагатай 70% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.3 | Малын халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах | Малын тоо сая.тол | 3.0 | 1.0 | 3.0 | I-IV улирал | Мал, амьтны халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээ технологит хугацааны дагуу хэрэгжиж байна. Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажил өнөөдрийн байдлаар 80%-ийн гүйцэтгэлтэй байна. Тодорхой үр дүнд хүрсэн – 90% |
| 2.4 | Хөдөө аж ахуйн салбарын дутагдалтай мэргэжилтэн бэлтгэх | Суралцагчийн тоо | 19 | 0 | 19 | II-IV улирал | 2024-2025 оны хичээлийн жилд нийт 14 суралцагчийн сургалтын төлбөр 50 хувийг хийх байсан боловч 2 суралцагч жилийн чөлөө авсан тул 12 суралцагчтай гэрээ байгуулан сургалтын төлбөрийг 100% шилжүүлсэн. Үр дүнтэй 100% |
| **Зорилт 3. Үйлдвэрлэл, хоршоо, худалдаа үйлчилгээний салбарын хөгжлийг эрчимжүүлж үр өгөөжийг нэмэгдүүлэх** | | | | | | | |
| 3.1 | Баянхонгорт үйлдвэрлэв-Цагаан сар 2025 үзэсгэлэн худалдаа зохион байгуулах | Хэрэгжилтийн хувь | 0 | 100% | 100% | I улирал | Орон нутгийн бичил, жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийг дэмжих, үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүнийг сурталчлан таниулах, худалдан борлуулах, ашиг орлогыг нэмэгдүүлэх, зах зээлд суурийг бататгах зорилгоор “Цагаан сар 2025” үзэсгэлэн худалдааг 1 дүгээр улиралд зохион байгуулж, 17 сумын 130 гаруй иргэн, аж ахуй нэгж оролцож, 140 сая төгрөгийн борлуулалтын орлоготой ажилласан. Үр дүнтэй 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.2 | Стратегийн хүнсний нөөц бүрдүүлэх | Нөөцийн махны хэмжээ тн | 0 | 0 | 80 | III-IV улирал | Стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх ажлыг "Баян Өсөх Агро" орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газарт эрх шилжүүлэн гүйцэтгүүлж байна. Тус газар нь бүрдүүлсэн нөөцийн нэр төрөл, тоо хэмжээ, чанар аюулгүй байдлын үзүүлэлт, бэлтгэх болон худалдах хугацаа, борлуулалтын төлөвлөгөөг 2025 оны 10 дугаар сард тайлагнаж ажиллана. Одоогийн байдлаар "Баян Өсөх Агро" ОНӨААТҮГ тариалалтын ажлыг эхлүүлээд байна.<br>Хаврын улиралд мах бэлтгэдэг орон нутгийн 3 ААН үйлдвэрийн аргаар 110тн, уламжлалт аргаар 172тн нөөцийн мах бэлтгэн зах зээлд хэрэглэгчдэд нийлүүлсэн.<br>Тодорхой үр дүнд хүрсэн – 90% |
| 3.3 | Шинэ хоршоо-Чинээлэг малчин хөдөлгөөний хэрэгжилтэд хяналт тавих, үр дүнг тооцох | - | Хяналтын тоо | 1 | 1 | IV улирал | Шинэ хоршоо-Чинээлэг малчин хөтөлбөрийн хүрээнд хагас жилийн байдлаар зээл авах хүсэлт гаргасан 301, судлагдаж байгаа 122, зээл авсан 275 иргэн 8.1 тэрбум төгрөгийн зээлийг авсан байна. Хяналтыг 4 дүгээр улиралд хэрэгжүүлнэ.<br>Тодорхой үр дүнд хүрсэн – 90% |
| **Зорилт 4. Байгаль орчныг хамгаалах, ногоон хөгжил, геологи, уул уурхайн бодлогыг хэрэгжүүлэх** | | | | | | | |
| 4.1 | "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх | - | Тарьсан модны тоо | 147,148 | 200,000 | II-IV улирал | "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн, аймгийн Засаг даргын 2025 оны 03 дугаар албан даалгаврын хүрээнд хаврын мод тарих ажлыг 5 дугаар сард зохион байгуулсан. Хаврын |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | мод тарих арга хэмжээний хүрээнд 18 сум 38252 ширхэг модыг шинээр, 5873 ширхэг модыг нөхөн тарилтанд тарьсан байна.<br>Тодорхой үр дүнд хүрсэн – 70% |
| 4.2 | Баянхонгор сумын Дуурсах 3-р багийн шинэ ойн зурваст хурын ус хуримтлуулах хөв байгуулах | 150.0 | Шинээр байгуулсан хөвийн тоо | 0 | 1 | I-III улирал | Баянхонгор сумын Дуурсах 3-р багийн шинэ ойн зурваст хурын ус хуримтлуулах хөв байгуулах ажлын зураг төсвийн гэрээг “Гидрофонтан” ХХК-тай байгуулж, магадлал хийгдэж 727,0 сая төгрөгийн төсөвтэй зургийг 2025 оны 04 дүгээр сард хүлээн авсан. Энэхүү хөв цөөрөм нь хаврын шар ус, зуны хур борооны үерийн 11446,80 м3 усыг хуримтлуулан ойн зурвас усалж, хуурайшилтийг бууруулах ач холбогдолтой юм. Аймгийн төсвөөс 150,0 сая төгрөг, Баянхонгор сумын төсвөөс 100,0 сая төгрөг нийт 250,0 сая төгрөг батлагдсан нь төсөвт өртөгт хүрэхгүй байгаа тул үлдэгдэл санхүүжилтийг шийдвэрлүүлэхээр Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яаманд албан бичиг хргүүлсэн. Мөн олон улсын төсөл, хөтөлбөр, сангуудаас санхүүжилт шийдүүлэх ажлын хүрээнд 2025 оны 06 дугаар сард зохион байгуулагдах “Уур амьсгалын өөрчлөлт ба орон нутгийн төлөвлөлт” форумд тус ажлыг танилцуулахаар бэлтгэж байна.<br>Тодорхой үр дүнд хүрсэн – 70% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.3 | Шинэжинст сумын гүний усны хяналтын цооногийг хяналтын нэгдсэн системд холбох | 40.0 | Хяналтын системд холбосон цооногийн тоо | 1 | 3 | II-III улирал | “Эрдэнэ Монгол” ХХК-тай хамтран Шинэжинст сумын гүний усны 2 ширхэг хяналтын цооногийг хяналтын нэгдсэн системд холбох ажлыг зохион байгуулж байна. Хяналтын логгер суурилуулах тоног төхөөрөмжийг худалдан авсан ба суурилуултын ажлыг 6 дугаар сард хийж гүйцэтгэнэ. Тодорхой үр дүнд хүрсэн – 70% |
| 4.4 | Уул уурхайн улмаас эвдэрч, орхигдсон талбайг нөхөн сэргээх | - | Талбайн хэмжээ, га | 287.24 | 330 | III-IV улирал | Хугацаа болоогүй. |
| 4.5 | Уул уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдтэй гэрээ байгуулж, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих | - | Гэрээний хэрэгжилтийн хувь | 90 | 95 | II-IV улирал | Өнгөрсөн онд 7 тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй гэрээ байгуулснаас “Ай Эн Ди” ХХК, “Вояжер минерал ресурсес” ХХК, “Одод гоулд” ХХК, “Монголболгаргео” ХХК, “Эрдэнэ Монгол” ХХК зэрэг 6 тусгай зөвшөөрөл эзэмшигчидтэй байгуулсан гэрээний хэрэгжилт 96 хувьтай дүгнэгдсэн. Аймгийн Засаг даргын 2025 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн А/155 дугаар захирамжаар “Эрдэнэ Монгол” ХХК, “Наранмандал Энтерпрайзес” ХХК-тай байгуулсан гэрээний хэрэгжилтэд хяналт шалгалт хийх ажлыг зохион байгуулсан ба “Наранмандал Энтерпрайзес” ХХК-ний хөрөнгө оруулалт дуусаагүй байгаа тул гэрээг дүгнэх боломжгүй байна. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 04 дүгээр сарын 02-ны өдрийн хуралдаанаар Тусгай зөвшөөрөл эзэмшигчидтэй 2025 онд гэрээ байгуулах асуудлыг судалж, санал өгөх ажлын хэсэг байгуулагдсан ба ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн гэрээ байгуулахаар хүлээгдэж байна.<br>Үр дүнтэй 100% |
| **Зорилт 5. Зам тээвэр, дэд бүтэц, хот байгуулалт, төлөвлөлт, газрын харилцааны бодлогыг хэрэгжүүлэх** | | | | | | | |
| 5.1 | Сумдын хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулан батлуулах | 1,915.0 | Сумын тоо | 3 | 16 | I-IV улирал | Аймгийн орон нутгийн хөгжлийн сан болон сумдын орон нутгийн хөгжлийн сангийн 1,300.0 сая төгрөгөөр Шинэжинст, Баян-Өндөр, Хүрээмарал, Жаргалант, Баянцагаан, Бөмбөгөр, Бууцагаан, Заг, Гурванбулаг, Баянговь, Баян-Овоо зэрэг 11 сумдын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний зураг төсвийн тендерийг зарлаж “Сонголт дизайн” ХХК, “Эрхэт констракшн” ХХК, “Өсөн үржих Констракшн” ХХК-д тус тус гэрээ байгуулж ажлыг гүйцэтгэж байгаа бөгөөд 4 дүгээр улиралд гэрээний дагуу хүлээлгэн өгөх юм.<br>Тодорхой үр дүнд хүрсэн – 70% |
| 5.2 | Аймгийн 2025 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах | - | Хэрэгжилтийн хувь | 0 | 100 | I-IV улирал | Аймгийн 2025 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд инженерийн шугам сүлжээ бүхий 3 газрыг эзэмшүүлэхээр тусган аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 3/18 дугаар тогтоолоор хэлэлцүүлэн |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | батлуулснаас Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 03 дугаар сарын 06-ны хуралдаанаар хэлэлцэн 644 м2 талбайг дуудлага худалдаагаар 2248 м2 талбайг төрийн байгууллагын зайлшгүй хэрэгцээнд зориулан эзэмшүүлэхээр батлагдсан.<br>Мөн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн хуралдаанаар аймгийн Засаг даргын Тамгын газар, Биеийн тамир, спортын газрын үйл ажиллагаанд шаардлагатай 18636 м2 газрыг нэмж эзэмшүүлэхээр аймгийн 2025 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний нэмэлт өөрчлөлтөд тусган батлуулж, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газарт хүргүүлсэн.<br>Үр дүнтэй 100% |
| 5.3 | Иргэнд газар өмчлүүлэх ажлыг зохион байгуулах | - | Газар өмчилсөн иргэний тоо | 12625 | 13000 | I-IV улирал | Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн Хурлын хуралдаанаар аймгийн хэмжээнд 2025 онд 716 иргэнд газар өмчлүүлэхээр газрын хэмжээ, байршил, зориулалтыг тогтоон, АИТХ-ын 3/19 дүгээр тогтоолоор батлуулсанаас Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн 574 иргэнд газар |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | өмчлүүлэхээр 119 дүгээр тогтоол батлагдсан. Тогтоолын дагуу 4 иргэнд газрыг өмчлүүлээд байна.<br>Үр дүнтэй 100% |
| 5.4 | Инженерийн шугам сүлжээ бүхий газрын харилцааны асуудлыг шийдвэрлэх | - | Шийдвэрлэлтийн хувь | 100 | 100 | I-IV улирал | Эхний хагас жилийн байдлаар давхардсан тоогоор 118 иргэн 15 аж ахуйн нэгжийн газрын харилцааны асуудлыг аймгийн Засаг даргын 58 захирамжаар бүрэн шийдвэрлэсэн.<br>Үр дүнтэй 100% |
| 5.5 | Баянхонгор сумын 3-р сургуулийн баруун урд уулзвараас нэгдсэн эмнэлгийн уулзвар хүртэлх авто замын ажлыг хийж гүйцэтгэх | Замын сан 2,049,0 | Замын урт км | 0 | 1,3 | III-IV улирал | Тус ажлыг Баянхонгор сумруу эрх шилжүүлж гүйцэтгэсэн бөгөөд тендэр сонгон шалгаруулалт зарлаж “Бридж Бюлдинг” ХХК шалгарсан бөгөөд авто замын суурийн далангийн ажлыг хийж гүйцэтгэж байна.<br>Үр дүнтэй 100% |

ХЭРЭГЖИЛТ ХЯНАСАН
БҮС, ОРОН НУТГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН
ХЭЛТСИЙН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Г.ЭНХБАЯР

ХЭРЭГЖИЛТ НЭГТГЭСЭН
БҮС, ОРОН НУТГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН Б.БИНДЭРЪЯА

# БҮС,ОРОН НУТГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Г.ЭНХБАЯРЫН 2025 ОНЫ 2 ДУГААР УЛИРЛЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Аймгийн Засаг даргын Тамгын газар
Нэгжийн нэр: Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт,бодлого төлөвлөлтийн хэлтэс

**Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ | Гүйцэтгэлийн түвшин | Нийт (70 оноо) |
|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 |
| 1. | Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт | 81.5% | 57,05 |

1. **Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийн хувь | Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор) |
|---|---|---|---|
| 1. | Арга хэмжээ №1.Шинээр гарч буй хууль тогтоомж, бодлого шийдвэрийг судалж мэдлэг ур чадвараа дээшлүүлэх | 100 | 15 |
| 2. | Арга хэмжээ №2.Төрийн албаны зөвлөлийн 7:4:10 сургалтад тогтмол хамрагдах | 100 | 15 |
| 3. | Арга хэмжээ №3.Удирдлагаас өгсөн үүрэг чиглэлийг чанартай, түргэн шуурхай хэрэгжүүлэх, удирдлагын манлайллыг хэрэгжүүлж ажиллах | 100 | 15 |
| **Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний дундаж оноо** | | | 15 |

2. **Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ**

| Д/д | Үзүүлэлт | Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор) |
|---|---|---|
| 1. | Хандлага, ёс зүй | 15 |
| 2. | Удирдан зохион байгуулах | 15 |
| 3. | Асуудал шийдвэрлэх | 15 |
| 4. | Манлайлах | 15 |
| 5. | Багаар ажиллах | 15 |
| 6. | Харилцаа | 15 |
| Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан) | | |
| 7. | Мэргэжлийн ур чадвар 1. | |
| 8. | Мэргэжлийн ур чадвар 2. | |
| 9. | Мэргэжлийн ур чадвар 3. | |
| **Хандлага, ёс зүй, ур чадварын дундаж оноо** | | 15 |

3. **Гүйцэтгэлийн үнэлгээ**

| Д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1. | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт ) | 57,05 |
| 2. | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт | 15 |
| 3. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ | 15 |
| 4. | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт | ..... |
| | **Нийт оноо =** | 87,05 |

Үнэлгээний мөрөөр авах арга хэмжээ / урхмшуулах, хариуцлага тооцох г.м /-санал:

Төстийн шууд захирагчийн тэмдэглэл / ажлын гүйцэтгэлийг хэрхэн сайжруулах зөвлөмж г.м /

***Үнэлгээ өгсөн:*** ***Төсвийн шууд захирагч***

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ *Т.ХИШИГБААТАР*

0320110002
9007342 ГСТ7121

2015.06.25.....(огноо)

***Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:*** ***Нэгжийн дарга:***

БҮС,ОРОН НУТГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Г.ЭНХБАЯР

.................... (огноо)